Үйлдвэрийн ойр орчимд гадаргын усны нөөц байхгүй. Харин үйл ажиллагаанд усыг унд ахуйн, бүтээгдэхүүн үйлдвэрлэл, зам болон ногоон байгууламжийг услахад ашиглаж байна. Технологийн хэрэглээний ус нь шулуутгагчийн хөргөлтөнд, катод угаах, үйлдвэрийн цех доторх нойтон цэвэрлэгээнд, уусмалын алдагдлыг нөхөх зориулалтаар хэрэглэгдэнэ. Үйлдвэрийн цэвэр усыг Уулын баяжуулах “Эрдэнэт” үйлдвэртэй цэвэр усаар хангах гэрээг байгуулж, үндсэн шугамнаас авч хэрэглэж байгаа бол үйлдвэрийн ногоон байгууламж, зам талбайг гүний худгаас ашигладаг.

Хүснэгт 10. Усны нөөцөд учруулж болзошгүй сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээ

| №    | Гол болон болзошгүй сөрөг нөлөөллүүд                                                                           | Сөрөг нөлөөллийг арилгах, бууруулах арга хэмжээ                                                                                                      | Хамрах хүрээ                                         | Нэгжийн зардал                       | Тоо хэмжээ | Нийт зардал, төг | Хэрэгжүүлэх хугацаа, | Эрхзүйн баримт бичиг                                   |
|------|----------------------------------------------------------------------------------------------------------------|------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------|------------------------------------------------------|--------------------------------------|------------|------------------|----------------------|--------------------------------------------------------|
| 1.   | Ногоон байгууламжийн усалгаа, уурын                                                                            | Гүний худгийн уст давхаргын ашиглалтын түвшинд хяналт тавих, зохих хэмжээнд ашиглах.                                                                 | Ногоон байгууламж, уурын зууханд ашиглах гүний худаг | Тоолуурын заалтын дагуу              |            |                  | Улирал бүр           | Усны тухай хууль, Байгалийн нөөц ашигласны тухай хууль |
| 2.   | зуухны үйл ажиллагаанд ашиглаж буй гүний усны нөөцөд хомсдол учирч болзошгүй                                   | Ус ашиглах дүгнэлтэнд зааснаас бусад зориулалтаар ус ашиглах, хуулийн шаардлагын дагуу ус ашиглах гэрээг хийж, төлбөр хураамжийг хугацаанд нь төлөх. | Уурын зуух, ногоон байгууламж усалгааны худаг        | Ус ашиглах дүгнэлтэнд тусгасны дагуу |            |                  | Жилийн турш          |                                                        |
| 3.   | Уусмал алдагдаж, гүний усны бохирдол үүсч болзошгүй                                                            | Гүний усны 1 цооногт автомат түвшин хэмжигч суурьлуулж турших, мэдээллийг жигдрүүлэх.                                                                | Мониторингийн цооног                                 | 30,000,000                           | 1 ширхэг   | 30,000,000       | Хоёрдугаар улиралд   |                                                        |
| 4.   | Цэвэрлэх байгууламжийн үйл ажиллагааны доголдлоос ус хөрсөнд алдагдаж, газар доорхи усыг бохирдуулж болзошгүй. | Цэвэрлэх байгууламжийн оролт, гаралтын уснаас улирал тутамд дээж авч шинжлэх, шаардлагатай засвар үйлчилгээг тогтмол хийх.                           | Цэвэрлэх байгууламж                                  | Дэд бүтцийн төлөвлөлтийн зардлаар    |            |                  | Улиралд 1 удаа       |                                                        |
| Нийт |                                                                                                                |                                                                                                                                                      |                                                      |                                      |            | 30 000 000       |                      |                                                        |

### 5.3. Газрын хэвлийд учруулж болзошгүй сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний төлөвлөгөө

Газрыг зөв зохистой ашиглахтай холбоотой Монгол Улсын хууль, тогтоомжуудын шаардлагууд, байгаль орчны стандартууд болон төслийн Байгаль орчны нарийвчилсан үнэлгээний шаардлагуудад нийцүүлэн ажиллах зорилтын хүрээнд төлөвлөгөөг боловсрууллаа. Бид аливаа үйл ажиллагаанаас газар хөндөх, хөрс хуулах ажилд хяналт тавьж, шимт хөрсийг стандартын дагуу хадгалах, тухайн талбайд шаардлагатай нөхөн сэргээлтийг төлөвлөхөд Тусгай зөвшөөрлөөр ажил гүйцэтгэх журмыг баталж, өдөр тутмын үйл ажиллагаанд мөрдлөг болгон ажиллаж байна.

*Хүснэгт 11. Газрын хэвлий, хөрсөн бүрхэвчид учруулж болзошгүй сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээ*

| №  | Гол болон болзошгүй сөрөг нөлөөллүүд                       | Сөрөг нөлөөллийг арилгах, бууруулах арга хэмжээ                                                                                             | Хамрах хүрээ                                  | Нэгжийн зардал, төг           | Тоо хэмжээ  | Нийт зардал, төг | Хэрэг-жүүлэх хугацаа | Эрхзүйн баримт бичиг                                                                      |
|----|------------------------------------------------------------|---------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------|-----------------------------------------------|-------------------------------|-------------|------------------|----------------------|-------------------------------------------------------------------------------------------|
| 1. | Газрын гадарга, хэвлий эвдэгдэх, доройтох, нөлөөлөлд өртөх | Хяналтгүйгээр газар хөндөхөөс сэргийлж газар хөндөх үйл ажиллагааг эхлүүлэхийн өмнө “Ухалт малталтын зөвшөөрөл авах, олгох, бүртгэл хөтлөх” | Үйлдвэрийн газар хөндөх бүхий л үйл ажиллагаа | Дотоод нөөц                   | Дотоод нөөц | Дотоод нөөц      | Жилийн турш          | MNS 5917:2008 "Уул уурхайн үйлдвэрлэлийн үйл ажиллагаагаар эвдэрсэн газрын нөхөн сэргээлт |
| 2. | Үйлдвэрийн бүсэд хатуу хог хаягдал үүсэх                   | Эко өдөрлөгийг тогтмол хэрэгжүүлэх, үйлдвэр орчимд их цэвэрлэгээ хийх                                                                       | Үйлдвэрийн бүс                                | 1,000,000                     | 1           | 1,000,000        | 3-р улирал           |                                                                                           |
| 3. | Хөрсөн бүрхэвч хамгаалал                                   | Газар хөндөх үйл ажиллагааны өмнө шимт хөрсний гүнийг тогтоож, тогтоосон хэмжээнд хуулж стандартын дагуу хадгалах.                          | Үйлдвэрийн газар хөндөх бүхий л үйл ажиллагаа | Дотоод нөөц                   | Дотоод нөөц | Дотоод нөөц      | Жилийн турш          | MNS 5916:2008 "Газар шорооны ажлын үед шимт хөрс хуулалт, хадгалалт,                      |
| 4. |                                                            | Шимт хөрсний хүнд металлын дээж шинжилгээг хийлгэх, бүртгэх.                                                                                | Хадгалагдаж буй болон шинээр үүсэх шимт хөрс  | 60,000                        | 20          | 1,200,000        | 3-р улиралд          |                                                                                           |
| 5. |                                                            | Шатах, тослох материалын хаягдлыг тусгайлан тосон авч, зөвшөөрөл бүхий байгууллагад хүргүүлэх                                               | Засварын болон ашиглалтын үйл ажиллагаа       | Гэрээнд туссан үнийн саналаар |             |                  | Жилийн турш          |                                                                                           |

|             |                              |                                                                                                                                 |                       |                   |    |         |             |  |
|-------------|------------------------------|---------------------------------------------------------------------------------------------------------------------------------|-----------------------|-------------------|----|---------|-------------|--|
| 6.          | Үер буух эрсдлээс сэргийлэх. | Цаг уурын мэдээг авч, балансын судалгааг хийх, уусмалын түвшин нэмэгдсэнээс цөөрөм халих, уусмал хөрсөнд алдагдахаас сэргийлэх. | Төслийн үйл ажиллагаа | 50,000            | 12 | 600,000 | Жилийн турш |  |
| <b>Нийт</b> |                              |                                                                                                                                 |                       | <b>18,000,000</b> |    |         |             |  |

## 6. НӨХӨН СЭРГЭЭЛТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ

Ачит-Ихт ХХК-ийн катодын зэсийн үйлдвэрийн онцлог нь олборлолт хийгдэхгүй тул үйл ажиллагаанаас газрын хэвлий эвдэгдэж, сүйтгэгдэхгүй эерэг нөлөөтэй төсөлд тооцогддог. Хэдий тийм ч бид үйл ажиллагаанаас өнгөн хөрс хөндөх, газар шорооны ажил эрхлэх тухай бүрт техникийн болон биологийн нөхөн сэргээлтийг хариуцлагатай гүйцэтгэхийг эрмэлзэн мэргэжлийн байгууллагуудтай хамтран ажилладаг.

Бид 2025 онд биологийн нөхөн сэргээлтийн ажлын хүрээнд Монгол улсын Ерөнхийлөгчийн 2021 оны 58 дугаар Зарлигийн дагуу “Тэрбум мод үндэсний хөдөлгөөний хүрээнд” 2022-2030 онд 3,0 сая модны тарьц суулгацын нөөцийг бүрдүүлэх зорилгоор мод үржүүлгийн газрын төслийг үргэлжүүлэхээр төлөвлөлөө.

### Хүснэгт. Нөхөн сэргээлтийн төлөвлөгөө

| №           | Нөхөн сэргээлтийн зорилт | Нөхөн сэргээлтийн арга хэмжээ                                                                                                 | Хэмжих нэгж | Тоо хэмжээ | Нийт зардал, төг                                                    | Хэрэгжүүлэх хугацаа ба давтамж | Эрхзүйн болон холбогдох баримт бичиг                         |
|-------------|--------------------------|-------------------------------------------------------------------------------------------------------------------------------|-------------|------------|---------------------------------------------------------------------|--------------------------------|--------------------------------------------------------------|
| 1           | Биологийн нөхөн сэргээлт | Тэрбум мод үндэсний хөдөлгөөний хүрээнд нийт тарих моддын ажлын төлөвлөгөө гаргаж, төрийн захиргааны байгууллагаар батлуулах. | ширхэг      | 1          | Мод үржүүлгийн газрын үйл ажиллагааны төсөвт тусгасан зардлын дагуу | 1-р улиралд                    | Монгол Улсын Ерөнхийлөгчийн зарлиг Дугаар 58                 |
| 2           |                          | Мод үржүүлгийн талбайд модны тарьц, суулгацын нөөц бүрдүүлэх.                                                                 | ширхэг      | 300,000    |                                                                     | 3-р улиралд                    | MNS 6253-2: 2011, Мод, сөөгний үр тарих. Техникийн шаардлага |
| 3           |                          | A1001 зам дагуу мөнгөлөг улиас тарих                                                                                          | ширхэг      | 100        | 3,100,000                                                           | 2-р улиралд                    | Мөнгөлөг улиас тарих аргазүйн зөвлөмж                        |
| <b>Нийт</b> |                          |                                                                                                                               |             |            | <b>3,100,000</b>                                                    |                                |                                                              |

“Ачит-Ихт” ХХК нь 2014 оноос эхлэн “Бүх нийтээр мод тарих” үндэсний өдрийг тэмдэглэн үйлдвэрийн талбайд ногоон байгууламж байгуулах ажлыг ажилтнууд болон гэрээт мэргэжлийн байгууллагатай хамтран өрнүүлэхээс гадна тус үйл ажиллагааг өргөжүүлэн тэлж Орхон аймгийн Байгаль орчин аялал жуулчлалын газар, Сум дундын ойн ангитай хамтран өөрийн компанийн нэрэмжит төгөлтэй болох зорилгоор Сархиа уул, хотын A1001 зам дагуу, Эрдэнэт хаалга орчимд голын урсац, гольдрол нэмэгдүүлэх зорилгоор мод тарих ажлуудыг зохион байгуулж байна. Цаашид бид нийт тарьсан моддын арчилгааг дулааны улиралд гэрээт ажилтнаар арчлуулж, моддын болон орчны ногоон байгууламжийн амьдралын үр дүнг өндөр байлгах ажлыг тогтмол зохион байгуулна.

**7. БИОЛОГИЙН ОЛОН ЯНЗ БАЙДЛЫГ ДҮЙЦҮҮЛЭН ХАМГААЛАХ АРГА ХЭМЖЭЭ**

“Ачит- Ихт” ХХК-ийн катодын зэс ялган авах төсөл нь нутгийн биологийн олон янз байдалд эерэг нөлөө үзүүлэхийг эрмэлзэж байна. Манай компани нь дүйцүүлэн хамгаалах ажлын хүрээнд иргэдэд ач холбогдол өндөр булгуудын эх ундаргыг хамгаалах, сэргээх ажлуудыг гүйцэтгэхээс гадна 2023 оноос хойш жил бүр голын усны нөөцийг хамгаалах, нэмэгдүүлэх зорилгоор хамгаалалтын зурвасыг үүсгэж ус чийгийг сайн барьдаг бургас, хайлаас зэрэг моддыг голын гольдрол дагуу тарьж, ургуулж байна. 2025 онд Хангал гол дагуух хамгаалалтын ажлыг үргэлжлүүлэхээр төлөвлөв.

*Хүснэгт 12. Дүйцүүлэн хамгаалах арга хэмжээ*

| №    | Дүйцүүлэн хамгаалах зорилт | Хамгаалах арга хэмжээ                                                                                                                | Арга хэмжээг хэрэгжүүлэх талбай                           | Тоо хэмжээ | Нийт зардал, төг | Хэрэгжүүлэх хугацаа ба давтамж | Эрх зүйн баримт бичиг                                                               |
|------|----------------------------|--------------------------------------------------------------------------------------------------------------------------------------|-----------------------------------------------------------|------------|------------------|--------------------------------|-------------------------------------------------------------------------------------|
| 1    | Голын гольдролыг хамгаалах | Хангал голын усны нөөцийг нэмэгдүүлэх, эрэг, хөрсний элэгдэл эвдэрлээс хамгаалах зорилгоор бургас моддыг тарих.                      | Эрдэнэт хотын хаалганы дэргэд Хангал голын гольдрол дагуу | 500 ширхэг | 6,168,000        | 4-р улиралд                    | Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний тухай хууль, Ачит Ихт ХХК-ийн БОННУ 2019 |
| 2    |                            | Хангал голын усны нөөцийг нэмэгдүүлэх, эрэг, хөрсний элэгдэл эвдэрлээс хамгаалах зорилгоор мөнгөлөг улиас моддыг тарьж, нутагшуулах. |                                                           | 60 ширхэг  | 1,400,000        | 2-р улиралд                    |                                                                                     |
| 3    |                            | Голын гольдрол дагуу тарьсан моддыг хамгаалах хамгаалалтын хашаа барих                                                               |                                                           | 206*66 м2  | 30,000,000       | 2,3-р улиралд                  |                                                                                     |
|      |                            |                                                                                                                                      |                                                           |            |                  |                                |                                                                                     |
| Нийт |                            |                                                                                                                                      |                                                           |            | 37,568,000       |                                |                                                                                     |

## 8. НҮҮЛГЭН ШИЛЖҮҮЛЭХ, НӨХӨН ОЛГОВОР ОЛГОХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨ

“Ачит Ихт” ХХК-ний катодын зэс үйлдвэрлэх төслийн үйл ажиллагаа нь “Эрдэнэт үйлдвэр” ТӨҮГ-тай байгуулсан “Газрыг хязгаарлагдмал эрхтэйгээр эзэмшүүлэх” гэрээний дагуу олгогдсон үйлдвэрийн районы 157.16 га талбайд явагдаж байна.

Үйлдвэрийн 1км-ийн бүсэд газар эзэмших, ашиглах эрхтэй айл өрх, аж ахуй нэгж, байгууллага байхгүй. Үйлдвэрээс 2.5-3 км зайд байрлах 6 малчин айл өрх амьдардаг. Иймд нөлөөлөлд өртөгч бүлгийн айл өрхийг шилжүүлэх асуудал төлөвлөгдөхгүй.

Харин Гамшгийн үед компанийн үйлдвэрийн ажилтнуудыг нүүлгэн шилжүүлэх арга хэмжээг гамшгаас хамгаалах ерөнхий төлөвлөгөөнд тусгаж хэрэгжүүлнэ. Гамшгийн эрсдэлд өртөж эрүүл мэндээрээ хохирох эрсдэлийг даатгалын журмаар зохицуулах ба эрсдэлд өртсөн тохиолдолд хууль тогтоомжийн дагуу нөхөн олговор олгоно.

Хүснэгт 13. Нүүлгэн шилжүүлэх төлөвлөгөө

| № | Төлөвлөгөөтэй эсэх                                                           | Хүн, хүчний тооцоо /штаб, мэргэжлийн анги/           | Химийн хорт бодисын нэр, тоо хэмжээ                                                                                                  | Техник хэрэгсэл |                               | Бэлэн байдлын үеийн нэг бүрийн хамгаалах хэрэгсэл /төрөл, тоо ширхэг/ |        |                |               |              |            |               |               |
|---|------------------------------------------------------------------------------|------------------------------------------------------|--------------------------------------------------------------------------------------------------------------------------------------|-----------------|-------------------------------|-----------------------------------------------------------------------|--------|----------------|---------------|--------------|------------|---------------|---------------|
|   |                                                                              |                                                      |                                                                                                                                      | 3               | 13                            | 10                                                                    | 100    | 25             | 200           | 1000         | 20         | 1             |               |
| 1 | “Ачит-Ихт” ХХК-ний гамшгаас хамгаалах ерөнхий төлөвлөгөөнд тусгагдсаны дагуу | Удирдлага<br>Штаб: 11 хүн<br>Мэргэжлийн анги: 23 хүн | Хүхрийн хүчил: H2SO4 – 7132.1 тн<br>Органик хандлагч Ликс: 32.4 тн<br>Кобальтын сульфат: 9.9 тн<br>Гуартек: 2.2 тн<br>Керосин:411 тн | Автобус         | Том оврын болон суудлын тэрэг | Хүчлээс хамгаалах хувцас MSA SAFETY                                   | 20х200 | Резинэн бээлий | Резинэн гутал | Хошуувч- P-2 | Амны хаалт | Нүүрний хаалт | Хороглох байр |

Нөхөн олговрыг шийдвэрлэх төлөвлөгөө

| № | Нөхөн олговрыг шийдвэрлэх арга хэмжээ       | Ажилтны тоо                                                 | Нэг ажилтны даатгалын зардал | Нийт зардал | Даатгалын компани |
|---|---------------------------------------------|-------------------------------------------------------------|------------------------------|-------------|-------------------|
| 1 | Ажил олгогчийн даатгал                      | 201                                                         | 23,938,348                   | 41,023,348  | Бодь-Даатгал      |
| 2 | Гэнэтийн ослын даатгал                      |                                                             | 9,045,000                    |             |                   |
| 3 | Эмчилгээний даатгал                         |                                                             | 8,040,000                    |             |                   |
| 4 | Хууль тогтоомжийн дагуу олгох нөхөн олговор | Эрсдэл гарсан үед өртсөн ажилтнуудад нөхөн олговрыг олгоно. |                              |             |                   |

## 9. ОСОЛ, ЭРСДЭЛИЙН МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ

“Ачит-Ихт” ХХК нь МУ-ын хууль, дүрэм журмууд болон олон улсын стандартад нийцсэн компанийн дотоод журмыг боловсруулан хэрэгжүүлэхээс гадна хууль, журмын зүйл заалтын шаардлагын дагуу тухайн жилд хэрэглэсэн Химийн бодисын орлого зарлагын мэдээг тогтмол гаргаж Орхон аймгийн Байгаль орчин аялал жуулчлалын газарт хүргүүлэн ажиллаж байна. Цаашид холбогдох баримт бичгийг боловсруулан мөрдлөг болгон ажиллана. Мөн үйлдвэрийн үйл ажиллагаанд дараах журам, зааварчилгааг баталж мөрдөн, эдгээрийг MNS ISO 45001:2018, ISO 14001:2015 стандартын хэрэгжилтийн болон бусад хууль, дүрэм журмын дагуу хөндлөнгийн болон дотоод аудитыг зохион байгуулж, тогтмол хяналт тавьж ажиллаж байна. Үүнд:

- Асгаралтын хариу арга хэмжээний журам
- Онцгой байдлын бэлэн байдал, хариу арга хэмжээний журам
- Тусгай зөвшөөрлөөр ажил гүйцэтгэх журам
- Химийн бодистой харьцаж ажиллах аюулгүй ажиллагааны дүрэм, зааврууд

Химийн бодисыг үйлдвэрийн талбайд MNS 6458:2014 стандарт шаардлагын дагуу баригдсан агуулахад хуурай болон шингэн бодис гэж ангилан хадгалж байна. Үйлдвэрийн үйл ажиллагаанд ашиглагдаж буй химийн бодис тус бүрт эрсдлийн үнэлгээг хийж, эрсдлийн үнэлгээ хийгдээгүй бодисыг ашиглахгүй байхыг шаардаж, ERP системд бүртгэж, тогтмол хяналт тавин ажиллаж байна.

2025 оны байдлаар төслийн хүрээнд нийт 71 нэр төрлийн химийн бодис зөвшөөрөлтэй хадгалагдан, ашиглагдана. Ашиглагдаж буй химийн бодисууд нь бүгд ХАЛМ-тай бөгөөд цаашид шаардлагад үл нийцэж буй ХАЛМ-тай химийн бодис байгаа эсэхэд тогтмол хяналт тавьж ажиллана.

*Хүснэгт 14. Химийн бодисын менежмент*

| № | Болзошгүй аюул, осол сөрөг нөлөөлөл | Урьдчилсан сэргийлэх, хамгаалах арга хэмжээ                                                                           | Хэрэгжих хэсэг, цар хэмжээ                           | Тоо хэмжээ       | Нийт зардал, төг           | Хэрэгжүүлэх хугацаа ба давтамж | Эрх зүйн баримт бичиг                          |
|---|-------------------------------------|-----------------------------------------------------------------------------------------------------------------------|------------------------------------------------------|------------------|----------------------------|--------------------------------|------------------------------------------------|
| 1 | Аюултай бодис асгарах               | Химийн бодисын асгаралтын үед авч хэрэгжүүлэх арга хэмжээний сургалтыг Орхон аймгийн ОБГ-тай хамтран зохион байгуулах | Химийн бодистой харьцаж ажиллаж буй нийт ажиллагсад. | 1 удаа           | 2,000,000                  | 1-р улирал                     | Химийн хорт болон аюултай бодисын тухай хууль, |
| 2 | Гамшиг ослын эрсдэл                 | Гамшгийн нрсдлийн үнэлгээний зөвлөмжийг хэрэгжүүлэх төлөвлөгөөг хэрэгжүүлэх                                           | Үйлдвэрийн бүхий л үйл ажиллагаанд                   | Хэмжих боломжгүй | Эрсдлийн удирдлагын зардал | 1-4-р улиралд                  | “Ачит Ихт” ХХК Гамшгийн эрсдлийн үнэлгээ 2024  |

|             |                                              |                                                                                                                             |                                                                                    |                             |                                   |               |                                               |
|-------------|----------------------------------------------|-----------------------------------------------------------------------------------------------------------------------------|------------------------------------------------------------------------------------|-----------------------------|-----------------------------------|---------------|-----------------------------------------------|
| 3           |                                              | Гамшгаас хамгаалах төлөвлөгөөнд тодотгол хийж хэрэгжүүлэх.                                                                  | Нийт ажилтнууд                                                                     | 1 удаа                      |                                   | 1-4-р улирлад | “Ачит Ихт” ХХК Гамшгийн эрсдлийн үнэлгээ 2024 |
| 4           |                                              | Химийн бодисыг хадгалах, ашиглах, тээвэрлэх үед гарч болзошгүй эрсдлийн үеийн төлөвлөгөөг хэрэгжүүлэх.                      | Үйлдвэрийн бүхий л үйл ажиллагаанд                                                 |                             | 2,000,000                         | Жилийн турш   |                                               |
| 5           | Химийн бодисын ашиглалтад хяналт тавих       | ХБ№1-12 маягтын дагуу бүртгэлийг тогтмол хөтлөх. /ХХБАБТХ-13.7, ХБАЗБХ-13/                                                  | Химийн бодис ашиглаж буй үйлдвэрийн бүхий л хэсэг                                  | Дотоод нөөц                 | Дотоод нөөц                       | Жилийн турш   | Химийн бодисын тухайх хууль                   |
| 6           | Сургалт                                      | Химийн бодистой харьцан ажилдаг ажилчдад жил бүр химийн бодисын сургалтанд хамруулах                                        | Химийн бодистой харьцаж ажилладаг лаборатори, уусгалт, EW, SX цехийн үйл ажиллагаа | Нийт 60 ажилтныг хамруулна. | Үйл ажиллагаа-Сургалтын зардлаар  | Жилийн турш   |                                               |
| 7           | Үйлдвэрийн ажиллагсдын эрүүл мэндэд нөлөөлөх | Нэг бүрийн хамгаалах хэрэслээр хангах, хор саармагжуулах бүтээгдэхүүнээр хангах, эрүүл мэндийн үзлэгт жилд 1 удаа хамруулах | Үйлдвэрийн нийт ажилтнууд                                                          | 209 ажилтныг                | Үйл ажиллагааны – ХАБ-ын зардлаар | Жилд 1 удаа   | ХАБЭА-н тухай хууль                           |
| <b>Нийт</b> |                                              |                                                                                                                             |                                                                                    |                             | <b>4,000,000</b>                  |               |                                               |

Химийн бодисыг ашиглах, хадгалах, тээвэрлэх үед осол тохиолдож байгаль орчинд нөлөөлөхүйц эрсдэл үүсэхээс урьдчилан сэргийлэх зорилгоор химийн бодистой харьцаж ажилладаг нийт ажилтнуудыг жил бүр сургалтад хамруулж, эрсдэлийн хяналт мониторингийн ажлыг “Орчны хяналт шинжилгээний хөтөлбөрт” тусгаж ажиллаж байна.

**10. ХОГ ХАЯГДЛЫН МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ**

Хог хаягдлын тухай хууль болон үйлдвэрийн хог хаягдлын хяналтын журмыг мөрдөж ажиллах, тус журмын хавсралтад дурдсан үйлдвэрийн үйл ажиллагаанаас үүсэх хог хаягдлын жагсаалтын дагуу ангилан ялгах дадал зуршлыг хэвшүүлэх.

Хүснэгт 15. Хог хаягдлын менежмент

| № | Хог хаягдлын ангилал                   | Сөрөг нөлөөллийг арилгах, бууруулах арга хэмжээ                                                                                                                             | Сөрөг нөлөөллийн хамрах хүрээ                         | Хэмж их нэгж | Нэгж зардал, төг | Тоо хэмжээ         | Нийт зардал, төг | Хэрэгжү үлэх хугацаа | Эрх зүйн баримт бичиг    |
|---|----------------------------------------|-----------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------|-------------------------------------------------------|--------------|------------------|--------------------|------------------|----------------------|--------------------------|
| 1 | Хог хаягдлын менежмент нэвтрүүлэх      | Үйлдвэрийн үйл ажиллагаанаас гарах нийт хаягдлын дахин ашиглах боломжийг нэмэгдүүлэх, эх үүсвэр дээр ангилалыг сайжруулах, түр хадгалах цэгийг стандартын дагуу тохижуулах. | Үйлдвэрийн бүх үйл ажиллагаанд                        | тоо          | Дотоод нөөцөөр   | 1                  | Дотоод нөөцөөр   | Жилийн турш          | Хог хаягдлын тухай хууль |
| 2 | Дахин ашиглах боломжгүй энгийн хаягдал | Орон нутгийн эрх бүхий байгууллагатай хог хаягдлыг устгуулах гэрээ байгуулах, журам, нормативын дагуу төлбөрийг төлөх                                                       | Үйлдвэрийн бүх үйл ажиллагаанд                        | Метр куб     | 11,500           | 364м <sup>3</sup>  | 4,186,000        | 7 хоног бүр          |                          |
| 3 | Дахивар хаягдал                        | Үйл ажиллагаанаас гарах бүхий л дахивар хаягдлыг ангилан цуглуулж, дахиварын цэгүүдэд шилжүүлэх.                                                                            | Үйлдвэрийн бүх үйл ажиллагаанд                        | -            | -                | -                  | Дотоод нөөцөөр   | Жилийн турш          |                          |
| 4 | Үйлдвэрийн                             | Уурын зуухны халуун үнсийг өөрийн талбайд хөргөж аюулгүй болсон хойно тээвэрлэн хүргэх.                                                                                     | Уурын зуухны үйл ажиллагаа                            | Метр куб     | 11,500           | 2100м <sup>3</sup> | 24,150,000       | Тухай бүр            |                          |
| 5 | Аюултай хог хаягдал                    | Тусгай эрх бүхий байгууллагад шилжүүлэх, тээвэрлүүлэх, устгуулах                                                                                                            | Аюултай хаягдал үүсгэгч цех, хэсгүүдийн үйл ажиллагаа | -            | -                | -                  | Гэрээний дагуу   | Тухай бүр            | АХХТХЦТ ДБУББТ журам     |

|             |                                  |                                                                                                    |                                            |   |   |   |                   |              |                          |
|-------------|----------------------------------|----------------------------------------------------------------------------------------------------|--------------------------------------------|---|---|---|-------------------|--------------|--------------------------|
| 6           | Химийн бодсын хаягдал, крад      | Хаягдлыг цуглуулж, овоолго дээрх зөвшөөрөгдсөн цэгт хаях                                           | SX- уусган хандлах цехийн үйл ажиллагаа    | - | - | - | Дотоод нөөцөөр    | Тухай бүр    | ХХБАБ тухай хууль        |
| 7           | Хаягдал тос масло                | Түр хадгалах, тусгай эрх бүхий байгууллагад шилжүүлэх, устгуулах                                   | Авто тээвэр, засварын цехийн үйл ажиллагаа | - | - | - | Дотоод нөөцөөр    | Тухай бүр    | АХХТХЦТ ДБУББТ журам     |
| 8           | Сургалт                          | Хог хаягдлын ангилан ялгалт, байгаль хамгаалах арга хэмжээний талаархи сургалтыг зохион байгуулах. | Үйлдвэрийн бүхий л үйл ажиллагааны хүрээнд | - | - | - | Дотоод нөөцөөр    | 2-р улиралд  | Хог хаягдлын тухай хууль |
| 9           | Бүх нийтийн цэвэрлэгээнд оролцох | Байгаль хамгаалах хавар, намрын сарын ажлын хүрээнд эзэнгүй дүүргийн хог хаягдлыг цэвэрлэх         | Аймгийн БОАЖГ-ын саналын дагуух талбайд    | - | - | - | Дотоод нөөцөөр    | Хавар, Намар | Хог хаягдлын тухай хууль |
| <b>Нийт</b> |                                  |                                                                                                    |                                            |   |   |   | <b>28,968,000</b> |              |                          |

## 11. ОРЧНЫ ХЯНАЛТ ШИНЖИЛГЭЭНИЙ ХӨТӨЛБӨР

“Ачит-Ихт” ХХК-ийн катодын зэс үйлдвэрлэх төслөөс байгаль орчинд үзүүлж болзошгүй сөрөг нөлөөллүүдийг тогтоох, түүнээс урьдчилан сэргийлэх, үүссэн нөлөөллийг бууруулах, арилгах арга хэмжээг бодит судалгаа, шинжилгээнд үндэслэн хэрэгжүүлнэ.

“Ачит-Ихт” ХХК орчны хяналт шинжилгээг “Агаар, гүний ус, хөрс”-нд Орхон аймгийн Ус Цаг Уур Орчны Шинжилгээний Төв-тэй жил бүр гэрээ байгуулж, шинжилгээг төлөвлөгөөний дагуу хийлгэж байна. 2025 онд гүний ус, хөрсний дээжээс хүнд металлын агууламжийг итгэмжлэгдсэн лабораторид шинжлүүлэхээр төлөвлөвөө. Мөн өөрийн лабораторид хуваарийн дагуу тогтмол дээж авч шинжлэн, хяналт тавин ажиллаж байна.

“Ачит-Ихт” ХХК-ийн катодын зэс үйлдвэрлэх төслөөс байгаль орчинд үзүүлж болзошгүй сөрөг нөлөөллүүдийг тогтоох, түүнээс урьдчилан сэргийлэх, үүссэн нөлөөллийг бууруулах, арилгах арга хэмжээг бодит судалгаа, шинжилгээнд үндэслэн хэрэгжүүлнэ.

Хүснэгт 16. Орчны хяналт, шинжилгээний хөтөлбөр

| №                                               | Хяналт шинжилгээ хийх үзүүлэлтүүд                                                                                                  | Хяналтын цэгийн байршил                                                                                                                                                                          | Хугацаа ба давтамж            | Нэгж зардал, төг | Нийт зардал, төг            | Тайлбар                                    | Баримтлах эрх зүйн баримт бичиг |
|-------------------------------------------------|------------------------------------------------------------------------------------------------------------------------------------|--------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------|-------------------------------|------------------|-----------------------------|--------------------------------------------|---------------------------------|
| 1. Агаарын чанарын мониторинг                   |                                                                                                                                    |                                                                                                                                                                                                  |                               |                  |                             |                                            |                                 |
| 1                                               | ✓ NO <sub>2</sub><br>✓ SO <sub>2</sub>                                                                                             | A1. Үйлдвэрийн талбай буюу SX, EW цехийн дунд<br>A2- Машины зогсоол<br>A3- Овоолгын доод хормой буюу PLS цөөрөм<br>A4-Уурын зуухны орчим<br>A5- 2-р овоолгын дээр<br>A6- Хүхрийн хүчлийн агуулах | улиралд 1, жилд 24 шинжилгээ  | 60,000           | 1,440,000                   | Орхон аймгийн УЦУОША                       | MNS 4585:2016                   |
| 2                                               | Агаар орчныг бохирдуулагч элементийн хяналт шинжилгээ хийлгэх                                                                      | Уурын зуухны янданд, хамтарч ажиллах байгууллагыг сонгох                                                                                                                                         | Тогтсон хугацаанд             |                  | Гэрээнд тусгагдсан зардлаар | Дэд бүтцийн хэлтэс, мэргэжлийн байгууллага | MNS 4585:2016                   |
| 3                                               | Орчны агаар дахь тоосжилтын хэмжилт шинжилгээг хийлгэх. (Нийт тоос)                                                                | Агаарын шинжилгээний үндсэн 6 байршилд                                                                                                                                                           | Жилдээ 1 удаа нийт 5 цэг дээр | 200,000          | 1,000,000                   | Мэргэжлийн байгууллага                     |                                 |
| 2. Хөрсний бүрхэвч, газар ашиглалтын мониторинг |                                                                                                                                    |                                                                                                                                                                                                  |                               |                  |                             |                                            |                                 |
| 4                                               | Хөрсний бүрхэвчийн хяналтын цэгүүдээс дээж авч шинжлүүлэх<br>Тодорхойлох элемент<br>PH, NH <sub>4</sub> , SO <sub>4</sub> , Fe, PO | S1- 2-р овоолгын доор<br>S2- Бодисын агуулахын дэргэд /Хүчлийн агуулах/<br>S3- Хог хаягдлын ойр орчим<br>S4- Уурын зуух<br>S5- Үйлдвэрийн ойр орчим                                              | Жилд 2 удаа, нийт 10 сорьц    | 60,000           | 600,000                     | Орхон аймгийн УЦУОШТ                       | MNS 5850:2019                   |

|                                                |                                                                                                                                       |                                                                                                                                                                                                                          |                                     |        |                             |                                                 |               |
|------------------------------------------------|---------------------------------------------------------------------------------------------------------------------------------------|--------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------|-------------------------------------|--------|-----------------------------|-------------------------------------------------|---------------|
| 5                                              | Хүнд металлын<br>Элемент<br>тодорхойлох: Cu,<br>Mo, Cd, Zn, As, Pb,<br>Cr, Ni                                                         | S1- 2-р овоолгын доор<br>S2- Бодисын агуулахын дэргэд<br>/Хүчлийн агуулах/<br>S3- Хог хаягдлын ойр орчим<br>S4- Уурын зуух<br>S5- Үйлдвэрийн ойр орчим                                                                   | Жилд 1 удаа,<br>нийт 10 сорьц       | 40,000 | 400,000                     | Улаанбаатар                                     | MNS 5850:2019 |
| 3. Гадаргын болон газрын доорх усны мониторинг |                                                                                                                                       |                                                                                                                                                                                                                          |                                     |        |                             |                                                 |               |
| 6                                              | Гүний усны<br>хяналтын<br>цооногуудаас дээж<br>авч хяналт тавих<br>Тодорхойлох<br>элемент:<br>pH, SO4, Cu                             | W1- Хяналтын 1-р цооног<br>W2- Хяналтын 2-р цооног<br>W3- Хяналтын 3-р цооног<br>W5- 100.000 цөөрмийн 2-р цооног<br>W6 - 100.000 цөөрмийн 3-р цооног<br>W7- 30.000 цөөрмийн 1-р цооног<br>W8- 30.000 цөөрмийн 2-р цооног | Сар бүр<br>тогтмол нийт<br>96 сорьц | 43,750 | 4,200,000                   | Орхон<br>аймгийн<br>УЦУОШТ<br>Гэрээний<br>дагуу | MNS 6148:2010 |
| 7                                              | Элемент<br>тодорхойлох: Mo,<br>Cd, Zn, As, Pb, Cr, Ni                                                                                 |                                                                                                                                                                                                                          | Жилд 2 удаа,<br>нийт 16 сорьц       | 40,000 | 640,000                     | Улаанбаатар                                     | MNS 6148:2010 |
| 4. Бусад                                       |                                                                                                                                       |                                                                                                                                                                                                                          |                                     |        |                             |                                                 |               |
| 8                                              | Мониторингийн<br>тайланг улирал<br>тутамд БОАЖГ<br>болон Сумын засаг<br>даргын дэргэдэх БО<br>хариуцсан<br>мэргэжилтэнд<br>хүргүүлэх. |                                                                                                                                                                                                                          | 3,6,9,12-р<br>саруудад              |        | Дотоод нөөц<br>бололцоогоор | Байгаль<br>орчны<br>ажилтан                     |               |
| 9                                              | Хур бороо, үер буух                                                                                                                   | УЦУОШГ-аас цаг агаарын<br>мэдээ тогтмол цаг агаарын мэдээ<br>авах                                                                                                                                                        | 12 сар                              | 50,000 | 600,000                     | Орхон<br>аймгийн<br>УЦУОШТ                      |               |
| Дүн                                            |                                                                                                                                       |                                                                                                                                                                                                                          |                                     |        | 8,880,000                   |                                                 |               |

## 12. БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨГ ХЭРЭГЖҮҮЛЭХ УДИРДЛАГА ЗОХИОН БАЙГУУЛАЛТЫН ТӨЛӨВЛӨГӨӨ

“Ачит-Ихт” ХХК-ийн катодын зэсийн үйлдвэр нь нийт 200 гаруй ажилтан, албан хаагчидтай бөгөөд мод тарих, орчныг засаж тохижуулах, хүн бүр байгаль хамгаалагч байх уриан дор хамтран ажиллахаас гадна компанийн удирдлагын менежментийн системээр хүний эрүүл мэнд, аюулгүй ажиллагаа, байгаль орчны асуудлыг цогц байдлаар авч үздэг. Мөн хууль журам, стандартын хэрэгжилтийг хангах, шаардлагыг биелүүлэх зорилт тавин ажиллаж байгаа бөгөөд Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээ, Газрын чанарын улсын хянан баталгаа болон бусад эрсдэлийн үнэлгээ зэрэг хяналт, мониторингийг зохих хууль журмын дагуу тогтмол хийлгэж, үр дүн, зөвлөмж, шаардлагыг үйл ажиллагаандаа тусган ажиллаж байна. 2025 онд дараах ажлуудыг хэрэгжүүлэхээр төлөвлөж байна.

Хүснэгт 17. Удирдлага зохион байгуулалтын төлөвлөгөө

| № | Төлөвлөсөн арга хэмжээ                                                                         | Урьдчилан тооцсон төсөв         | Хэрэг-жүүлэх хуваарь | Хариуцсан албан тушаалтан | Тайлбар                                                                                                                           |
|---|------------------------------------------------------------------------------------------------|---------------------------------|----------------------|---------------------------|-----------------------------------------------------------------------------------------------------------------------------------|
| 1 | Байгаль орчны менежментийн тогтолцооны ISO 14001:2015 стандартын баталгаажилтын аудит хийлгэх. | Гэрээлэгч байгууллагын саналаар | 9 сард               | ХАБЭАБО хэлтэс            | Төслийн хүрээнд Iso 14001:2015 стандартыг нэвтрүүлэн хэрэгжүүлж 2022, 2023, 2024 онд баталгаажуулалтыг хийлгэж, гэрчилгээг авсан. |
| 2 | Газрын чанарын хянан баталгаажилтыг эрх бүхий байгууллагаар хийлгэх.                           | Гэрээлэгч байгууллагын саналаар | 2-р улиралд          | ХАБЭАБО хэлтэс            | 2015, 2020 онуудад газрын хянан баталгаажилт хуулийн шаардлагын дагуу хийгдсэн.                                                   |
| 3 | 1МВт чадалтай, 2МВт.ц багтаамж бүхий цэнэг хуримтлуур, нарны цахилгаан станц суурьлуулах.      | Үйл ажиллагааны зардалд         | Жилийн турш          | Төслийн нэгж              | Үйлдвэрийн цахилгаан хангамжийн системтэй зэрэгцээ ажиллах нарны цахилгаан станцийг суурьлуулж, ашиглах ажлууд хийгдэнэ.          |
| 4 | Байгаль орчны гүйцэтгэлийн аудитыг эрх бүхий байгууллагаар хийлгэх                             | Гэрээлэгч байгууллагын саналаар | 1-р улиралд          | ХАБЭАБО хэлтэс            | 2019, 2022 онуудад гүйцэтгэгдсэн.                                                                                                 |
|   | <b>Нийт</b>                                                                                    |                                 |                      |                           | <b>10,000,000</b>                                                                                                                 |

### 13. 2025 ОНЫ БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТИЙГ НӨЛӨӨЛЛИЙН БҮСИЙН ОРШИН СУУГЧДАД ТАЙЛАГНАХ ТӨЛӨВЛӨГӨӨ

“Ачит-Ихт” ХХК-ийн катодын зэс үйлдвэрлэх төсөл “Эрдэнэт үйлдвэр” ТӨҮГ-ын үйлдвэрийн бүсэд орших бөгөөд энэ бүсэд байнгын оршин суугч байхгүй хэдий ч Байгаль хамгаалах чиглэлээр хэрэгжүүлж байгаа ажлууд түүн дотроо орчны хяналт шинжилгээний хөтөлбөр болон нөхөн сэргээлтийн ажлыг тогтмол хэрэгжүүлэхийн ач холбогдол, үр дүнг хэрхэн сум, багийн иргэдэд ойлгомжтой, хүртээмжтэй байдлаар хүргэх арга замын талаар Баянцагаан багийн засаг дарга, холбогдох нэгж хэлтэстэй ярилцан оновчтой арга хэлбэрийг сонгон хэрэгжүүлнэ.

Хүснэгт 18. Байгаль орчны менежментийн төлөвлөгөөний хэрэгжилтийг тайлагнах хуваарь

| № | БОХТ-ний биелэлтийг тайлагнахад оролцогч талууд    | Зохион байгуулах хугацаа тов | Тайлагнах зардал, төг    | Хариуцан зохион байгуулах албан тушаалтан/ажилтан    | Зохион байгуулах газар |
|---|----------------------------------------------------|------------------------------|--------------------------|------------------------------------------------------|------------------------|
| 1 | Үйлдвэрийн удирдлагад                              | Тогтсон хугацаанд            | Дотоод нөөц бололцоогоор | ХАБЭАБО-н хэлтсийн менежер,<br>Байгаль орчны ажиглан | Үйлдвэрийн байранд     |
| 2 | Компанийн хэмжээнд мэдээлэл, танилцуулга хийх      | Жилд 1 удаа                  | Дотоод нөөц бололцоогоор |                                                      |                        |
| 3 | Баян-цагаан багийн Оршин суугчдад танилцуулах      | Жилд 1 удаа                  | 1,000,000                |                                                      | Багийн соёлын төвд     |
| 4 | Орон нутгийн Байгаль орчин аялал жуулчлалын газарт | Хагас жилд 1 удаа            | Дотоод нөөц бололцоогоор |                                                      |                        |
| 5 | Эрх бүхий байгууллагад тайлангаа хүргүүлэх         | Тогтсон хугацаанд            | Дотоод нөөц бололцоогоор |                                                      |                        |
|   | Нийт                                               |                              |                          | 1,000,000                                            |                        |